



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/27/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт.....	15
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/40

БОГД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БУРМАА ТАНАА

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол дагуу Богд сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Богд сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан, мөн АДБОУС 1240 (АОУС 240) дагуу сонгосон горим сорилоор доорх алдаа зөрчил илэрсэн нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Орон нутгийн өмчийн 2019 оны үзлэг тооллогоор 41,500.0 мянган төгрөгийн хөрөнгө дутагдуулсныг өмнөх оны санхүүгийн аудитаар хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх албан шаардлага өгч, аймгийн Цагдаагийн газрын эдийн засгийн

005020792

гэмт хэрэгтэй тэмцэх тасагт хүрүүлсэн гэх боловч өнөөг хүртэл хохирол барагдаагүй байна.

Дээрх нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5.1-д заасан "Төрийн өөрийн өмчид энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж болох дараах эд хөрөнгө хамаарна:", "төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө" гэсэн заалт, санхүүгийн тайлангийн "Оршин буй байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>61,068,573.00</u>	<u>74,962,573.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	61,068,573.00	74,962,573.00
354	Хангамжийн материал	47,737,573.00	61,631,573.00
35410	Бичиг хэргийн материал	4,537,975.00	4,352,975.00
35420	Аж ахуйн материал	43,117,598.00	44,036,598.00
35430	Сэлбэг хэрэгсэл	70,000.00	13,230,000.00
35450	Барилгын засварын материал	12,000.00	12,000.00
35600	Мал амьтад	13,331,000.00	13,331,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,021,807,286.79</u>	<u>961,186,640.84</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,021,807,286.79	961,186,640.84
392	Биет хөрөнгө	1,008,219,286.79	947,598,640.84
39201	Барилга, байгууламж, орон сууц	521,649,982.81	529,303,068.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(115,710,489.34)	(140,081,407.97)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	180,864,800.00	190,864,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(112,413,823.99)	(130,733,783.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	139,441,165.50	156,114,165.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(124,972,200.08)	(131,005,618.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	174,703,311.20	176,983,311.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(42,420,401.22)	(62,735,807.73)
39209	Зам, гүүрийн байгууламж	438,474,252.00	455,474,252.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(165,912,510.92)	(188,596,469.24)
39214	Бусад үндсэн хөрөнгө	227,933,200.00	227,933,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(113,417,999.17)	(136,221,069.25)
39217	Ном	0.00	300,000.00
393	Биет бус хөрөнгө	13,588,000.00	13,588,000.00
39301	Програм хангамж	559,000.00	559,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(559,000.00)	(559,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,588,000.00	13,588,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,082,875,859.79</u>	<u>1,036,149,213.84</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>0.00</u>	<u>8,771,908.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	8,771,908.00
413	Өглөг	0.00	8,771,908.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	133,508.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	8,638,400.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,082,875,859.79</u>	<u>1,027,377,305.84</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,082,875,859.79	1,027,377,305.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	474,836,479.36	474,836,479.36
51101	Өмч: - төрийн	474,836,479.36	474,836,479.36
512	Хуримтлагдсан үр дүн	446,748,454.75	395,113,431.93
51210	Өмнөх үеийн үр дүн	446,748,454.75	450,611,985.88
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	(55,498,553.95)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	161,290,925.68	157,427,394.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,082,875,859.79</u>	<u>1,036,149,213.84</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	432,184,241.00	505,364,283.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,717,731.00	61,155,387.00
120	Нийтлэг татварын бус орлого	42,717,731.00	61,155,387.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,717,731.00	405,850.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,870.00	405,850.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	984,500.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	41,705,361.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /ҮХ/	0.00	54,127,537.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /БМ/	00.00	6,622,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	389,466,510.00	444,208,896.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,332,210.00	43,657,896.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	8,204,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,332,210.00	32,403,896.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,050,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	375,134,300.00	400,551,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	375,134,300.00	400,551,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	520,093,373.96	557,249,159.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	520,093,373.96	557,249,159.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	484,458,529.49	543,620,273.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,832,652.53	243,645,914.97
210101	Үндсэн цалин	224,435,880.39	243,645,914.97
210105	Гэрээт ажлын хөлс	15,396,772.14	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,052,248.00	30,111,464.63
210201	Тэтгэврийн даатгал	25,327,230.00	21,259,726.20
210202	Тэтгэмжийн даатгал	1,213,512.00	2,138,819.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	946,757.00	1,829,643.10
210204	Ажилгүйдлийн даатгал	233,158.00	375,157.13
210205	Эрүүл мэндийн даатгал	2,331,591.00	4,508,119.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,220,036.00	17,974,120.00
210301	Гэрэл, цахилгаан	3,274,262.00	5,507,999.00
210302	Түлш, халаалт	14,945,774.00	12,466,121.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,014,720.94	45,396,147.24
210401	Бичиг хэрэг	4,972,968.00	6,063,148.00
210402	Тээвэр, шатахуун	16,268,155.94	26,730,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,060,197.00	669,396.96
210404	Ном, хэвлэл	174,800.00	363,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	9,394,752.28
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,538,600.00	2,174,900.00
2105	Нормативт зардал	176,000.00	3,970,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	3,970,000.00

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	176,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,134,000.00	150,000.00
210604	Урсгал засвар	1,134,000.00	150,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,774,500.00	4,055,600.00
210702	Дотоод албан томилолт	3,065,000.00	4,055,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,709,500.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,917,504.00	44,804,208.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,729,504.00	41,240,208.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,188,000.00	3,564,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,336,868.02	153,512,818.39
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,246,850.00	32,388,313.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,457,000.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	130,633,018.02	120,624,505.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,634,844.47	13,628,886.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,403,000.00	2,098,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,668,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,735,000.00	2,098,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,231,844.47	11,530,886.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,230,884.47	11,167,527.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-87,909,132.96	-51,884,876.39
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	16,298,626.35	6,474,300.73
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	16,298,626.35	6,474,300.73
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-16,298,626.35	-6,474,300.73
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-104,207,759.31	-58,359,177.12

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/
2021.12.31**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	390,478,880.00	444,614,746.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,012,370.00	405,850.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,012,370.00	405,850.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,012,370.00	405,850.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,870.00	405,850.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	984,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	389,466,510.00	444,208,896.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,332,210.00	43,657,896.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	8,204,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,332,210.00	32,403,896.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,050,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	375,134,300.00	400,551,000.00

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	375,134,300.00	400,551,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	390,478,880.00	435,124,746.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	390,478,880.00	435,124,746.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,324,035.53	421,495,859.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,271,249.53	243,144,644.54
210101	Үндсэн цалин	215,580,444.12	243,144,644.54
210105	Гэрээт ажлын хөлс	16,690,805.41	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,033,751.00	31,278,467.66
210201	Тэтгэврийн даатгал	20,568,650.00	22,046,461.55
210202	Тэтгэмжийн даатгал	2,398,471.00	2,311,734.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,894,786.00	1,843,203.13
210204	Ажилгүйдлийн даатгал	470,168.00	485,933.77
210205	Эрүүл мэндийн даатгал	4,701,676.00	4,591,134.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,220,036.00	18,185,120.00
210301	Гэрэл, цахилгаан	3,274,262.00	3,596,329.00
210302	Түлш, халаалт	14,945,774.00	14,588,791.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,672,645.00	31,625,814.64
210401	Бичиг хэрэг	3,877,868.00	5,302,948.00
210402	Тээвэр, шатахуун	16,193,180.00	15,699,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	874,197.00	669,396.96
210404	Ном, хэвлэл	200,000.00	388,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	8,992,919.68
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,527,400.00	572,400.00
2105	Нормативт зардал	295,100.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	295,100.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	11,057,000.00
210602	Тавилга	00.00	58,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	10,999,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,679,000.00	4,055,600.00
210702	Дотоод албан томилолт	3,065,000.00	4,055,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,614,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,403,254.00	49,182,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,839,254.00	45,618,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,749,000.00	32,966,813.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,572,000.00	32,466,813.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,177,000.00	500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,154,844.47	13,628,886.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,923,000.00	2,098,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,668,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,255,000.00	2,098,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15,231,844.47	11,530,886.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,230,884.47	11,167,527.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	9,490,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	9,490,000.00

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	9,490,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	9,490,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	9,490,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-9,490,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/
2021.12.31**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,836,479.36	210,225,930.61	502,021,209.13	00.00	1,187,083,619.10
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	474,836,479.36	210,225,930.61	502,021,209.13	00.00	1,187,083,619.10
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-104,207,759.31	00.00	-104,207,759.31
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,836,479.36	161,290,925.68	446,748,454.75	00.00	1,082,875,859.79
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,836,479.36	161,290,925.68	446,748,454.75	00.00	1,082,875,859.79
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	3,863,531.13	00.00	3,863,531.13
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	474,836,479.36	161,290,925.68	450,611,985.88	00.00	1,086,739,390.92
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-3,863,531.13	00.00	00.00	-3,863,531.13
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-55,498,553.95	00.00	-55,498,553.95
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	474,836,479.36	157,427,394.55	395,113,431.93	00.00	1,027,377,305.84

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/
2021.12.31**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	401,551,000.00	389,789,322.84	11,761,677.16	97.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	401,551,000.00	389,789,322.84	11,761,677.16	97.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	399,451,000.00	387,691,322.84	11,759,677.16	97.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	249,410,000.00	243,144,644.54	6,265,355.46	97.5
210101	Үндсэн цалин	249,410,000.00	243,144,644.54	6,265,355.46	97.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,265,200.00	31,278,467.66	1,986,732.34	94.0
210201	Тэтгэврийн даатгал	23,571,300.00	22,046,461.55	1,524,838.45	93.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,340,000.00	2,311,734.77	28,265.23	98.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,915,300.00	1,843,203.13	72,096.87	96.2
210204	Ажилгүйдлийн даатгал	494,400.00	485,933.77	8,466.23	98.3
210205	Эрүүл мэндийн даатгал	4,944,200.00	4,591,134.44	353,065.56	92.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,734,500.00	18,185,120.00	2,549,380.00	87.7
210301	Гэрэл, цахилгаан	4,260,000.00	3,596,329.00	663,671.00	84.4
210302	Түлш, халаалт	16,474,500.00	14,588,791.00	1,885,709.00	88.6
2104	Хангамж, бараа материалын зардал	32,175,000.00	31,925,814.64	249,185.36	99.2
210401	Бичиг хэрэг	5,375,300.00	5,382,948.00	-7,648.00	100.1
210402	Тээвэр, шатахуун	15,700,000.00	15,699,950.00	50.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	991,100.00	669,396.96	321,703.04	67.5
210404	Ном, хэвлэл	608,600.00	608,200.00	400.00	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,000,000.00	8,992,919.68	7,080.32	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	572,400.00	-72,400.00	114.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,968,300.00	17,967,000.00	1,300.00	100.0
210602	Тавилга	6,968,300.00	6,968,000.00	300.00	100.0
210604	Урсгал засвар	11,000,000.00	10,999,000.00	1,000.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	4,397,000.00	4,055,600.00	341,400.00	92.2
210702	Дотоод албан томилолт	4,397,000.00	4,055,600.00	341,400.00	92.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,251,000.00	5,887,863.00	363,137.00	94.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,687,000.00	2,323,863.00	363,137.00	86.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35250000.00	35246813.00	3,187.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,750,000.00	34,746,813.00	3,187.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2100000.00	2098000.00	2,000.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,100,000.00	2,098,000.00	2,000.00	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	2,098,000.00	2,000.00	99.9

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	401,551,000.00	389,789,322.84	11,761,677.16	97.1
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	400,551,000.00	389,383,472.84	11,167,527.16	97.2
132001	Орон нутгийн төсвөөс	400,551,000.00	389,383,472.84	11,167,527.16	97.2
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	405,850.00	594,150.00	40.6
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	405,850.00	594,150.00	40.6
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	22.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,332,210.00	43,294,537.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,332,210.00	43,294,537.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,332,210.00	43,294,537.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,332,210.00	43,294,537.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,332,210.00	43,294,537.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,332,210.00	43,294,537.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,332,210.00	43,294,537.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	8,204,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,332,210.00	32,039,576.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	3,050,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт төсвийн гүйцэтгэлийн аудит хийлгэх хүсэлтийг 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 1/241 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг ЗДТГ-ын дарга Б.Бурмаа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Ган-Өлзий оны эхнээс 2021.11.03-ны өдөр хүртэл, 2021.11.03-наас тайлант он дуустал Б.Алтантуяа нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Богд сумын Засаг даргын Тамгын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сумын орон нутгийн нийгэм эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсыг чандлан сахиулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд оршино.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийн хэрэгжүүлнэ.

Төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагаа

Төрийн албаны үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүү, хяналт аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 520,093.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,200.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,640.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 3,899.8 мянган төгрөг байгаа тул төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,726.6 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,068.6	74,962.6	13,894.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	61,068.6	74,962.6	13,894.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,021,807.3	961,186.6	(60,620.6)

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө	1,697,213.7	1,751,119.8	53,906.1
Хуримтлагдсан элэгдэл	(675,406.4)	(789,933.2)	(114,526.7)
Нийт хөрөнгө	1,082,875.9	1,036,149.2	(46,726.6)
Өр төлбөр	-	8,771.9	8,771.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,082,875.9	1,027,377.3	(55,498.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,082,875.9	1,036,149.2	(46,726.6)

Бараа материалын дансны үлдэгдэл 74,962.6 мянган төгрөг болж 13,894.0 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 919.0 мянга, сэлбэг хэрэгсэл 13,160.0 мянган төгрөгөөр өсөж, бичиг хэргийн материал 185.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,751,119.8 мянган төгрөг болж 53,906.1 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-гийн хөрөнгөөр 41,364.5 мянга, бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 12,763.0 мянга, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 9,490.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэнтэй холбоотой байна. Тайлант онд 9,711.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,765,252.4 мянган төгрөг болж 14,013.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Санал хүргүүлсэн зардлаас цалингийн зардлыг 29,130.4 мянга, ЭМНДШ-ийг 7,599.4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,195.0 мянга, хангамж, материалын зардал 6,829.2 мянга, эд хогшил худалдан авах зардал 35,641.7 мянга томилолтын зардал 6,783.0 мянга төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 452,098.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 92,092.4 мянган төгрөгөөр бууруулж 360,005.7 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 401,551.0 мянга мянган төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс 400,551.0 мянга, өөрийн орлогоор 1,000.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр төсвөөс 400,551.0 мянган төгрөгийн санхүүжилт авч өөрийн орлогоор 405.9 мянган төгрөгийг төвлөрүүлэн, 389,779.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 11,167.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 389,779.0 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа бөгөөд тайлант онд цалингийн зардал 6,265.4 мянга, ЭМНДШ-ийн зардал 1,986.7 мянга,

байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2,549.4 мянга, томилолтын зардал 341.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь 2021 онд нэмэлт санхүүжилтийн дансаар Статистикийн хэлтсээс тооллогын зардалд 933.9 мянга, аймгийн ЗДТГ-аас өвс тээвэрлэлтийн зардалд 1,938.3 мянга, ЗГ-аас усны үнийн хөнгөлөлтөд 2,832.0 мянга, тусгаарлах байрны төлбөр 4,809.0 мянга, эмнэлгийн дээврийн засварт 23,904.7, хандивын орлого 1,050.0 мянга, цахим тендерийн орлого 595.0 мянга, шүлхий өвчний 2,700,0 хамтарсан багийн зардалд 300.0 мянга, давсны орлого 2,750.0 мянган төгрөг нийт 43,657.9 мянган төгрөг төвлөрч 43,294.5 мянган төгрөгийн зарцуулан оны эцэст 363.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Төрийн захиргааны албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж улирал тутамд дүгнүүлэн ажилласан. Засаг даргын тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 4 бүлэг 62 заалттай баталж жилийн эцсийн байдлаар 94.3%-тай хэрэгжсэн.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 557,249.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 37,155.8 мянган төгрөгөөр буюу 7.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд цалин, ЭМНДШ, хангамж, бараа материал, тогтмол зардал өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 490,850.1 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 456,373.9 мянган төгрөгийн 126 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол 34,476.2 мянган төгрөгийн 23 мэдээг хугацаа хоцроож байршуулсан тул Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх зөвлөмжийг төсөв захирагчид өгөв. Харин 2 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	3	6	2
2	Хагас жил	4	4	0	4	0
3	Улирал бүр	1	4	2	2	0
4	Сар бүр	3	36	33	3	0
5	Тухай бүр	8	96	88	8	0
6	Нийт	27	151	126	23	2

3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Тайлант онд 401,551.0 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 389,779.0 мянган төгрөгийг зарцуулж, 11,772.0 мянган төгрөг буюу 2.9 хувийг хэмнэсэн байна.

- Албан томилолтын зардлыг 4,397.0 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 4,055.6 мянган төгрөг зарцуулж 341.4 мянган төгрөг хэмнэжээ.

- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 21,940.0 мянган төгрөгөөр төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 18,185.1 мянган төгрөг зарцуулж, анх баталсан дүнгээс 3,754.9 мянган төгрөг буюу 17.1 хувь хэмнэсэн нь ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20 хувь бууруулж хэмнэх дээрх тогтоолын 1.8 дах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд хүнс, болон үдийн цайны зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 174.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 41,500.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага өгч, 2,543.0 мянган төгрөгийн зөвлөмж өгснийг Богд сумын ЗДТГ-ын даргын 2021.12.06-ний өдрийн 2/211 тоот албан бичгээр хариуг ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хуулийн байгууллагад шилжүүлсэн хөрөнгөтэй холбоотой асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 73,359.3 мянган төгрөгийн 4 зөрчил илэрсэн тул зөрчил давтан гаргахгүй байх, таслан зогсоох зөвлөмж хүргүүлэв.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

Орон нутгийн өмчийн 2019 оны үзлэг тооллогоор 41,500.0 мянган төгрөгийн хөрөнгө дутагдуулсныг өмнөх оны санхүүгийн аудитаар хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх албан шаардлага өгч, аймгийн Цагдаагийн газрын эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх тасагт хүрүүлсэн гэх боловч өнөөг хүртэл хохирол барагдаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хуулийн байгууллагад өгсөн асуудлыг эрчимжүүлэн, төсвийг хохиролгүй болгох.

2.1. Илрүүлэлт:

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 2,750.0 мянган төгрөгийн давсны орлогыг төвлөрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 23.11-д заасан "Газар, байгалийн баялгийн нөөцийг хуульд заасан хэлбэрээр эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого нь төсвийн орлого байна" гэсэн заалтыг зөрчиж, байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид давсны орлогыг Түгээмэл тархацтай ашигт малтмалын ангиллаар төсвийн орлогын бүрэлдэхүүнд авч төсвийн орлогын бүрэлдэхүүнд оруулан, төвлөрүүлж байх.

3.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд оруулбал зохих 490,850.1 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллийг байршуулахаас 456,373.9 мянган төгрөгийн 126 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол 34,476.2 мянган төгрөгийн 23 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээг цаг хугацаанд нь байршуулж байх.

4.1. Илрүүлэлт:

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 21,940.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 18,185.1 мянган төгрөг зарцуулж Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8¹ дахь заалтаар 20 хувь буюу 4,388.0 мянган төгрөг хэмнэхээс 3,754.9 мянган төгрөг буюу 17.1 хувь хэмнэсэн нь тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй

Богд сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Цаашид байгууллагын удирдлага Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Богд сумын ЗДТГ	4	79,359.3	0	0	0	0	0	0	4	79,359.3

_____оОо_____